ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН ДАРГА Ж.ГАЛ-ЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар

Нэгжийн нэр: Орон зайн өгөгдөл, дэд бүтцийн газар

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 84,3% | 59 |

2. **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1.<br>Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | 100% | 15 |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Удирдлагын академийн Төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах | 100% | 15 |
| 3. | Арга хэмжээ 3.<br>ХААИС-д суралцах | 100% | 15 |
| 4. | Арга хэмжээ 4.<br>Байгууллагаас болон төслөөс, олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдах | 100% | 15 |
| 5. | Арга хэмжээ 5.<br>Дотоодын болон олон улсын хурал, зөвлөгөөнд оролцож, мэдлэг, мэдээлэл авах | 100% | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | |

3. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 15 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 15 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 15 |
| 4. | Манлайлах | 15 |
| 5. | Багаар ажиллах | 15 |
| 6. | Харилцаа | 15 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | / |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | |

| | | |
|---|---|---|
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | |
| **Дундаж оноо** | | 15 |

### 4. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт) (70 хүртэлх оноо) | 59 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (15 хүртэлх оноо) | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ ( Нэгжийн даргын үнэлгээ ) (7 хүртэлх оноо) | 15 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих) (..... оноо) | |
| **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 89 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

ГЗБГЗЗЕГ-ЫН ДАРГА А.ЭНХМАНЛАЙ

2025.06.17

9128321 9024010028

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга***

*ОЗӨДБГ-ЫН ДАРГА* Ж.ГАЛ

2025.06.17

# ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратегийн төлөвлөгөөний зорилго 1.15. Салбарын хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах, батлуулах** | | | | | | | |
| **1.15.1** | **Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах, санал авах, олон нийтээр хэлэлцүүлэх, эрх бүхий байгууллагад өргөн барих, батлуулах ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **5 хуулийн үзэл баримтлалын төсөл** | - | **Газрын багц хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг эцэслэн боловсруулж, газрын багц хуулийн төслийг батлуулахад шаардлагатай ажлыг зохион байгуулсан байна.** | | |
| 1.15.1.5 | Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулахад хамтран ажиллах | Үйл ажиллагаа | Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл | Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. | **Эхний хагас жилд:** Хуулийн үзэл баримтлалыг боловсруулж, батлуулна. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад хамтран ажилласан байна. | Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр шинэчлэн боловсруулж, батлуулахаар ЗГХЭГ-т 2025 оны 01 дүгээр сарын 17-ний өдөр хүргүүлсэн.<br>Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 02 дугаар сарын 17, 18-ны өдөр Ажлын хэсэг болон хуулийн зөвлөх багтай хамтран дахин сайжруулан боловсруулах ажилд оролцон холбогдох саналууд өгөв.<br>Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг дахин | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулж, батлуулахаар 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 1/1419 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Газрын даргын А/148 дугаар тушаалаар байгуулагдсан Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж 2025 оны 04.28, 05.06, 05.08, 05.11, 05.14-ны өдрүүдэд хуулийн төслийг сайжруулан боловруулахад оролцов.<br>2025 оны 06 дугаар сарын 02, 05-ны өдрүүдэд хуулийн төслийг ААН, төрийн байгууллагуудын дунд хийсэн хэлэлцүүлэгт санал солилцох, тайлбар, мэдээлэл хийх үүрэгтэй оролцов. | |
| 1.15.1.6 | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхэд шаардлагатай ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа, Урсгал зардал | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөл | Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулсан. | **Эхний хагас жилд:**<br>Хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, батлуулсан байна.<br>Хуулийн төслийг зөвлөх багтай хамтран боловсруулж дууссан байна. | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн зөвлөх үйлчилгээний багтай хамтран 2025 оны 02 дугаар сарын 19, 20-ний өдөр боловсруулсан.<br>Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг 2025 оны 03 дугаар сарын 21-ны өдөр Даргын дэргэдэх зөвлөлийн 07 дугаар хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.<br>Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар 2025 оны 05 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сарын 12-ны өдөр 1/1630 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | |
| 1.15.1.7 | Хаягжуулалтын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг боловсруулахад хамтран ажиллах | Үйл ажиллагаа, Урсгал зардал | Хаягжуулалтын тухай хуулийн төсөл | Хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсан. | **Эхний хагас жилд:**<br>Хуулийн үзэл баримтлалыг боловсруулж, батлуулна.<br>Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зөвлөх багтай хамтран боловсруулж дууссан байна. | Хаягжуултын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг боловсруулж, ДДЗ-ийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1/301 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Хууль, зүй, дотоод хэргийн сайд нар Хаягжуулалтын хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хамтран баталсан.<br>Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/144 дүгээр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тушаалаар байгуулагдан 2 удаа хуралдсан.<br>Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр БНСУ-ын Дотоод хэрэг, Аюулгүй байдлын яам болон Газар, геоматик (LX) корпорац, WUVUS ХХК-ын төслийн багтай 2025 оны 03 дугаар сарын 25-аас 28-ны өдрүүдэд хамтарч ажилласан.<br>Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулж, бүрдлийн хамт 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 1/1896 дугаартай албан бичгээр батлуулахаар ЗГХЭГ-т хүргүүлсэн. | |
| 1.16.1.9 | Монгол Улсын 2026 оны төсвийн төлөвлөгөөнд санал өгөх | Үйл ажиллагаа | Санал-1 | Монгол Улсын Их Хурлын 2025 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан. | **Эхний хагас жилд:** Геодези, зураг зүй, мэдээлэл технологийн чиглэлээр хийгдэх ажлууд тэдгээрийн төсвийн тооцоог боловсруулж, 2026 оны төсөвт тусгуулахаар ЗГХЭГ-т хүргүүлнэ. | Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр холбогдох төсвийн саналыг СЭЗХ-т хүргүүлэв.<br>Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд холбогдох төсвийн саналыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр СЭЗХ-т хүргүүлсэн. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.20. Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх хууль эрх зүйн орчинг бий болгох** | | | | | | | |
| **1.20.1** | **Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийг дагалдан гарах баримт бичгийг боловсруулж, батлуулахаар хүргүүлэх** | **Үйл ажиллагаа** | **1 стандарт** | **Орон зайн суурь 18 өгөгдлийн техник үзүүлэлтийг Үндэсний стандарт болгон батлуулсан.** | **Үндэсний стандартын төслийг эцэслэн боловсруулагдсан байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.20.1.1 | ISO 19119:2016 Газарзүйн мэдээлэл-Үйлчилгээ, ISO 19115 Газар зүйн мэдээлэл-Метадата стандартыг орчуулах, батлуулах; | Үйл ажиллагаа, Урсгал зардал | 1.ISO 19157-1.2023 Өгөгдлийн чанар стандарт;<br>2.ISO 19115 Газар зүйн мэдээлэл-Метадата стандарт;<br>3.ISO 19119:2016 Үйлчилгээ стандарт; | 2024 онд ISO 19157-1.2023 Өгөгдлийн чанар стандартыг боловсруулсан. | **Эхний хагас жилд:**<br>Стандартын төсөл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлсэн байна.<br>- ISO 19115:2019 "Газар зүйн мэдээлэл-Метадата стандарт";<br>- ISO 19119:2016 " Газарзүйн мэдээлэл-Үйлчилгээ стандарт" | Тус ажлын хүрээнд ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025 оны 02 дугаар сарын 06-ны А/36 тушаалаар Үнэлгээний хороог байгуулж, холбогдох нэгжүүдээс санал авч 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдөр **Багц-1 АД/2025-24** дугаар Ажлын даалгаврыг батлуулсан.<br>Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан. Үүнд:<br>- 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдөр зарлаж 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдөр тендерийг нээсэн. Тус тендерт нэг ч оролцогч материал ирүүлээгүй тул тус тендер амжилтгүй болсон.<br>- 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдөр цахим системээр дахин зарлаж 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр нээсэн. Тус тендерт шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтын дагуу оролцогчдын тендерээс татгалзсан тухай мэдэгдлийг хүргүүлэн дахин зарласан. | |
| 1.20.1.2 | MNS6925 1:18 Газар зүйн мэдээлэл-Өгөгдөл техникийн үзүүлэлт стандартын дагуу бусад байгууллагын санг хөрвүүлэх ажил | Урсгал зардал | Стандартын дагуу хөрвүүлэн мэдээллийн сангийн тоо | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:**<br>MNS6925 1:18 Газар зүйн мэдээлэл-Өгөгдөл техникийн үзүүлэлт стандартын дагуу бусад байгууллагын санг хөрвүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлсэн байна. | Тус ажлын хүрээнд ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025 оны 02 дугаар сарын 06-ны А/36 тушаалаар Үнэлгээний хороог байгуулж, холбогдох нэгжүүдээс санал авч 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдөр **Багц-2 АД/2025-23** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар бүхий Ажлын даалгаврыг батлуулсан.<br>Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг "Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем"-ээр зохион байгуулсан. Үүнд:<br>- 2025 оны 02 дугаар арын 14-ны өдөр зарлаж 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдөр тендерийг нээсэн. Тендерт нэг ч оролцогч материал ирүүлээгүй тул тус тендер амжилтгүй болсон.<br>- 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдөр цахим системээр дахин зарлаж 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр нээсэн. Тус тендерт шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтын дагуу оролцогчдын тендерээс татгалзсан тухай мэдэгдлийг хүргүүлэн дахин зарласан. | |

## ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Стратеги төлөвлөгөөний зорилго 2.1. Бүсчилсэн хөгжлийг дэмжиж, төвлөрлийг сааруулах Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн оновчтой хуваарийг тогтоох | | | | | | | |
| **2.1.2** | **Газар зүйн нэрийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж иргэд олон нийтэд үйлчилгээ үзүүлэх** | **Үйл ажиллагаа** | **214805 нэрийн мэдээллийн санг шалгаж засварласан.** | **15 аймгийн 114 сум, нийслэлийн 5 дүүргийн газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн санг нэгтгэсэн.** | **Газар зүйн нэрийн нэгдсэн мэдээллийн сан, систем үүсгэж иргэд, олон нийтийг үнэн зөв, түүхэн, уламжлалт газар зүйн нэрийн мэдээллээр хангасан байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2.2 | Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг сайжруулан хөгжүүлж, хэрэглээнд гаргах төслийг хамтран хэрэгжүүлэх | Гадаадын хөрөнгө оруулалт | 1 төсөл | БНСУ-ын Дотоод хэрэг аюулгүй байдлын яам, LX-тэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. | **Эхний хагас жилд:**<br>Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангаж, хамтран ажилласан байна. | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр "Монгол Улсын хаягийн мэдээллийн системийг шинэчлэх" төслийн санхүүжилтийг уламжилж өгөх тухай албан бичиг боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 1/108 дугаартай албан бичиг илгээсэн. Тус бичгийн хариу 2025 оны 01 дүгээр сарын 23-нд Сангийн яамруу уламжлагдсан болно.<br>БНСУ-ын Дотоод хэрэг, Аюулгүй байдлын яам, Газар, геоматик LX корпорац болон WUVUS ХХК-ын холбогдох мэргэжилтнүүд 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс 03 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсад ажиллах бэлтгэл ажлыг хангав. Үүнд:<br>- ЗГ-ын Хэрэг эрхлэх газар, ГХЯ-нд холбогдох мэдээллийг хүргүүлэх;<br>- Хэлэлцүүлэг хийх зардлын тооцоо, хөтөлбөр боловсруулж батлуулах;<br>- ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонготой хийх уулзалтыг зохион байгуулах;<br>- Улаанбаатар хотын Сөүлийн гудамжинд байршуулсан замын тэмдэгтэй танилцах бэлтгэл ажлыг хангах.<br>Төслийн багтай хамтран Монгол Улсын хаягийн мэдээллийн системийг сайжруулах төслийн бэлтгэл ажлыг хангах, МУ-ын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Хаягжуулалтын тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дүн шинжилгээ хийж, зөвлөмж өгөх хэлэлцүүлгийг зохион байгуулсан.<br>Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг хэрэглээнд гаргах ажлыг Чингэлтэй дүүргээс эхлэн нэвтрүүлж эхлэхээр бэлтгэл ажлыг хангаН ажиллаж байна. | |
| 2.2.1.3 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг байгууллагуудын мэдээллийн сантай холбож, дундын мэдээллийн сан байгуулах | Урсгал зардал | Дундын мэдээллийн сан-1 | 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ДДЗХ-аар тус ажлын явцын тайланг хэлэлцүүлж дүгнэсэн. | **Эхний хагас жилд:**<br>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн өгөгдлийн санг шинэчлэх системийн шийдлийг гүйцэтгэгчтэй хамтран боловсруулсан байна. | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр систем хөгжүүлэгч компанитай уулзалт зохион байгуулж, цаашид хийгдэх ажил болон тулгамдаж байгаа асуудлын талаар хэлэлцсэн. Мөн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн ДДЗХ-аар гэрээт ажлын гэрээний хугацааг сунгах талаар хэлэлцэж хурлын шийдвэрийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2025/19 дугаартай нэмэлт гэрээ байгуулсан. ГЗБГЗЗЕГ-ын газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 9 дүгээр хурлаар эцсийн үр дүнг хэлэлцэж тус системийг хүлээн авч, хэрэглээнд нэвтрүүлэх шийдвэр гарсан. Хурлын шийдвэрийн дагуу Оюуны өмчийн газарт 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 1/1525 дугаартай албан бичгээр тус системд зохиогчийн эрх авах тухай хүсэлт гаргасан. Оюуны өмчийн газрын даргын 2025 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/54 дугаар тушаалаар №16766 дугаарт бүртгэж, гэрчилгээ олгосон. Мөн холбогдох төрийн байгууллагуудад "Дундын мэдээллийн сан" хэрэглээнд нэвтэрсэн тухай албан бичиг хүргүүлэн ажиллаж байна. | |
| 2.2.1.5 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлэх, хяналт тавьж ажиллах | Урсгал зардал | Систем хөгжүүлсэн байдал | Газрын кадастр, Хаяг, Газрын нэгдмэл сан, Хот байгуулалтын кадастрын систем хэрэглээнд нэвтэрсэн. | **Эхний хагас жилд:** Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлтийн ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна. | Тус ажлын хүрээнд ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны А/70 тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо байгуулагдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааны цахим системээр 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр зарлаж 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр тендерийг нээж үнэлгээний хороо оролцогчдын тендерийг хянан үзэж, үнэлэх үйл ажиллагааг зохион байгуулсан ба гүйцэтгэгчээр Эрхэт инноваци ХХК шалгарч гэрээ байгуулсан. | |
| 2.2.1.6 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн өгөгдлийн санг бие даасан байдалд шилжүүлэх ажил | Урсгал зардал | Цахим системийн тоо | - | **Эхний хагас жилд:** Цахим системийн өгөгдлийн санг шинэчлэн зохион байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. | 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр АД/2025-31 дугаартай "ГНСУНЦС-ын өгөгдлийн санг шинэчлэн зохион байгуулах, бие даасан байдалд шилжүүлэх" ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Тус үйлчилгээний захиалагчийг төлөөлөх эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлэх хүсэлтээ 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1/764 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Үнэлгээний хороо хуралдаж, 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр www.tender.gov.mn цахим хаягт тус ажлыг зарласан. Тендерийг 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр нээсэн. Эрхэт-Инноваци ХХК хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарсан. ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 30.1-д заасан хугацаа дуусаагүй тул гэрээ байгуулж, ажил эхлэх асуудал хүлээгдэж байна. | |
| **Стратегийн төлөвлөгөөний зорилго 2.4. Салбарын хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах, батлуулах** | | | | | | | |
| **2.4.1** | **Хууль тогтоомж сурталчлах** | **Улсын төсөв, бусад эх үүсвэр** | **Иргэд, олон нийтэд хууль тогтоомжийг тухай бүр сурталчилсан эсэх** | | **Хуульд батлахаар заасан хэм хэмжээний актыг бүрэн батлуулсан байх** | | |
| 2.4.1.1 | Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээллэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сургалтын тоо<br><br>Хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн тоо | 5 удаагийн сургалт, мэдээллийн цагийг зохион байгуулсан. | Газрын харилцааны салбарт шинээр болон шинэчлэн батлагдсан эрх зүйн баримт бичгийг салбарын мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэх, танилцуулах сургалтыг зохион байгуулсан байна. | - Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн мэдээллийн системийн үйл ажиллагааны журам, 2 дугаар хавсралтаар Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам тус тус батлагдсантай холбоотойгоор албаны үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, Хаягийн мэдээллийн систем болон Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдөр 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нийт албан хаагчдад цахимаар, 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны албан хаагчдад танхимаар зохион байгуулсан.<br>- 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр байгууллагын фэйсбүүк хуудсанд “Геопортал цахим систем”-ийн танилцуулга бүхий богино хэмжээний видео хийж байршуулсан бөгөөд тус видео 589 шэйр, 24.8 мянган үзэлт авсан байна.<br>- “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн мэдээллийн системийн үйл ажиллагааны журам”, “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг албаны үйл ажиллагаанд хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр 21 аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны газрын удирдлага, албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг цахимаар зохион байгуулсан.<br>- ГЗБГЗЗЕГ-ын албан ёсны цахим хуудас болон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | олон нийтийн цахим сүлжээнд нийтэлсэн мэдээ, мэдээллийг тухай бүр өөрийн сошиал хуудсаар дамжуулан олон нийтэд түгээсэн. | |
| 2.6.2.5 | "Газрын зургийн систем хийх" ТЭЗҮ боловсруулах | Урсгал зардал | ТЭЗҮ-1 | 2024 онд Геодези, зураг зүйн удирдлагын нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Геодези, зураг зүйн системийг хөгжүүлэх Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. | Тус тендер шалгаруулалтын Ажлын даалгаврыг боловсруулан Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр АД/2025-18 дугаартай батлуулсан. Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/53 дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулсан. Тендер шалгаруулалтыг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр худалдан авах ажиллагааны https://tender.gov.mn/ цахим системд нийтэлсэн.<br>2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр тендерийг нээж 1 оролцогчийн ирүүлсэн тендерийг хянан үзэж үнэлэн Ц.Дашзэвгэ ахлагчтай багт 2025.04.04-ны өдрийн А/116 дугаар тушаалаар гэрээ байгуулах эрх олгож, 2025.04.17-ны өдрийн 2025/57 дугаартай гэрээ байгуулан ажлыг эхлүүлэв. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2.7. Геодези, зураг зүйн цахим үйлчилгээ нэвтрүүлэх** | | | | | | | |
| **2.7.1** | **Газар зүйн нэрийн мэдээллийн дэд систем хөгжүүлэх** | **Улсын төсөв** | **Геодези, зураг зүйн цахим систем-5** | **Геопорталаар дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэх боломж бүрдсэн.** | **Цахим үйлчилгээ бүрэн нэвтэрсэн байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.7.1.8 | Газар зүйн нэрийг полигонжуулах, арга аргачлал боловсруулах ажил (Сүхбаатар аймаг) | Урсгал зардал | Ажил-1, Арга аргачлал-1 | 2021-2022 онд Сүхбаатар аймгийн газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил хийсэн. | **Эхний хагас жилд:** Газар зүйн нэрийг полигонжуулах, арга аргачлал боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлсэн байна. | Тус тендер шалгаруулалтын Ажлын даалгаврыг боловсруулан Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр АД/2025-05 дугаартай батлуулсан. Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/38 дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулсан.<br>Тендер шалгаруулалтыг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр худалдан авах ажиллагааны https://tender.gov.mn/ цахим системд нийтэлсэн.<br>2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр тендерийг нээж 3 оролцогчийн ирүүлсэн тендерийг хянан үзэж үнэлэн, шаардлага хангасан тендер ирээгүй тул бүх тендерээс татгалзсан тухай мэдэгдлийг 2025.04.02-ны өдрийн 1/1066, 1/1067, 1/1065 дугаартай албан бичгээр оролцогчдод хүргүүлэв.<br>Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд шаардлагатай өөрчлөлтийг оруулж Газрын даргаар 2025.04.17-ны өдөр батлуулан шалгаруулалтыг дахин зарлав.<br>2025.05.09-ны өдөр тендерийг нээж 4 оролцогчийн ирүүлсэн тендерийг хянан үзэж "хамгийн сайн" тендер ирүүлсэн оролцогч болох "Инженер геодези" ХХК-нд 2025.05.30-ны өдрийн А/220 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар тушаалаар гэрээ байгуулах эрх олгож, 1/1962 дугаартай албан бичгээр гэрээ байгуулах эрх олгосон болохыг мэдэгдсэн.<br>Тендерт ирүүлсэн бусад оролцогчдод шалгараагүй тухай мэдэгдлийг 2025.05.30-ны өдрийн 1/1961, 1/1963, 1/1964 дугаартай албан бичгээр хүргүүлэв.<br>ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 30.1-д заасан хугацаа дуусаагүй тул гэрээ байгуулж, ажил эхлэх асуудал хүлээгдэж байна. | |
| 2.7.1.9 | Цахим системүүдэд зохиогчийн эрх авах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Цахим системийн тоо | 2024 онд 6 системд зохиогчийн эрх авч патентжуулсан.<br>Үүнд:<br>1.Салбарын тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрх олгох<br>2.Монпос GNSS-ийн онлайн боловсруулалт<br>3.Солбицол хооронд хөрвүүлэх систем<br>4.Архивын цахим систем<br>5.Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим систем<br>6.Газрын нэгдмэл сангийн цахим систем | **Жилийн эцэст:**<br>Шинээр хөгжүүлж хүлээн авсан болон одоо ашиглагдаж буй цахим системүүдэд зохиогчийн эрх авах ажлыг зохион байгуулна. | Оюуны өмчийн газарт 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 1/1525 дугаартай албан бичгээр дундын мэдээллийн сан системд зохиогчийн эрх авах тухай хүсэлт гаргасан. Оюуны өмчийн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/54 дугаар тушаалаар №16766 дугаарт бүртгэж, гэрчилгээ олгосон. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2.10. Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх замаар салбарын хэмжээнд цахим шилжилт хийх үйл ажиллагааг дэмжих** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.10.1** | **Блокчейнд суурилсан Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем, орон зайн өгөгдлийн Геопортал цахим системийн хөгжүүлэлт** | **Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Үйл ажиллагаа** | **Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем, орон зайн өгөгдлийн Геопортал цахим систем** | **Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн.** | **Улсын хэмжээнд цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.** | | |
| 2.10.1.9 | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах | Урсгал зардал, Үйл ажиллагаа | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системд хийсэн нэмэлт хөгжүүлэлтийн тоо түүний хэвийн үйл ажиллагаа | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн 2.0 хувилбарыг 2024 онд хэрэглээнд нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Геопортал цахим системд шаардлагатай тохируулга, хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэн хэвийн үйл ажиллагааг хангасан байна. | Хэвийн үйл ажиллагааг хангах ажиллаж байна. | |
| 2.10.1.25 | Байгууллагын дата төв, цахим системүүдэд мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрсдлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах | Урсгал зардал | Мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрдлийн үнэлгээний дүгнэлт | Монгол улсын Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17.1.7 дахь хэсэгт заасныг үндэслэн 2024 онд байгууллагын зарим цахим системүүдэд мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрдлийн үнэлгээг хийлгэсэн. | **Эхний хагас жилд:** Байгууллагын дата төв, цахим системүүдэд мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрдлийн үнэлгээ хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. | Тус газрын даргын 2025 оны А/120 дугаар тушаалаар батлагдсан "байгууллагын дата төвд мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэх ажил" гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулан худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Гүйцэтгэгч "Систем центр" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаар гэрээний төслийг хүргүүлэн ажиллаж байна. | |
| 2.10.1.26 | Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн | Урсгал зардал | Орон зайн өгөгдлийн дэд | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн | **Эхний хагас жилд:** | Тус тендер шалгаруулалтын Ажлын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Геопортал цахим системийн өгөгдлийн санг шинэчлэн зохион байгуулах, хэрэглэгчийн програм хангамжийн хөгжүүлэлт ажил | | бүтцийн Геопортал цахим системийн хэвийн үйл ажиллагаа | Геопортал цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. | Геопортал цахим системийн хөгжүүлэлтийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. | даалгаврыг Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр АД/2025-32 дугаартай батлуулсан. Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/81 дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулсан. Тендер шалгаруулалтыг 2025 оны 02 дугаар сарын 28-ний өдөр худалдан авах ажиллагааны https://tender.gov.mn цахим системд нийтэлсэн.<br>2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр тендерийг нээж, 1 оролцогчийн ирүүлсэн тендерийг хянан үзэж үнэлэн, шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй болох тухай мэдэгдлийг 2025.04.11-ны өдрийн 1/1242 дугаартай албан бичгээр хүргүүлэв.<br>Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд шаардлагатай өөрчлөлтийг оруулж Газрын даргаар 2025.04.14-ны өдөр батлуулан шалгаруулалтыг дахин зарлав.<br>2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр тендерийг нээж, 2 оролцогчийн ирүүлсэн тендерийг хянан үзэж үнэлэн шаардлага хангасан тендер ирээгүй тул бүх тендерээс татгалзсан тухай мэдэгдлийг 2025.05.26-ны өдрийн 1/1868, 1/1869 дугаартай албан бичгээр оролцогчдод хүргүүлэв.<br>Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шаардлагатай өөрчлөлтийг оруулж Газрын даргаар батлуулан 2025.06.06-ны өдөр тендер шалгаруулалтыг дахин зарлав. | |
| 2.10.1.27 | Байгууллагад зориулсан лавлагаа мэдээлэл хүргүүлэх, зарлан мэдээлэх, нийлүүлэгч байгууллагуудын ачаалал тэнцвэржүүлэх хөгжүүлэлтийн ажил | Урсгал зардал | Хөгжүүлэлт-1 | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Хөгжүүлэлтийн ажил хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлсэн байна. **Жилийн эцэст:** Хөгжүүлэлтийн ажлыг шалгаж хүлээн аван Геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгнө. | 2025 оны Худалдан авах төлөвлөгөөнөөс хасагдсан. | |
| 2.10.1.28 | Орон зайн өгөгдлийн мэдээллийн санд чанарын шалгалт хийж, баяжуулалт, атрибут мэдээг бүрдүүлэх ажил | Урсгал зардал | Атрибут мэдээ бүрдүүлэх ажил -1 | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Орон зайн өгөгдлийн мэдээллийн санд чанарын шалгалт хийж, баяжуулалт, атрибут мэдээг бүрдүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлсэн байна. | Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/152 дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулсан. Тендер шалгаруулалтыг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр худалдан авах ажиллагааны https://tender.gov.mn цахим системд нийтэлсэн. 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр тендерийг нээнэ. | |

## ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| **Д/д** | **Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **Суурь түвшин** | **Зорилтот түвшин** | **Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар** | **Гүйцэтгэлийн хувь** |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратегийн төлөвлөгөөний зорилго 3.9. Салбарын бодлого, салбар хоорондын уялдаа холбоог хангах, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **3.9.1** | **Салбарын болон бусад төрийн байгууллагуудын төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүдийн уялдааг хангах хурал, зөвлөгөөн зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Зохион байгуулсан арга хэмжээний тоо** | **Газрын харилцаа эрдэм шинжилгээний хурал жил бүр зохион байгуулагдсан.** | **Салбарын бодлогын баримт бичгүүд, төлөвлөгөөний уялдааг хангах зорилгоор бусад төрийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран зохион байгуулж үр дүнг нийтэлсэн байна.** | | |
| 3.9.1.1 | Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хуралдаан зохион байгуулах, хурлаас өгсөн үүрэг даалгаврыг албажуулах, тайлагнах | Үйл ажиллагаа | Хуралдааны тоо<br>Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөл<br>Орон зайн мэдээллийн технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл | 2024 онд Орон зайн мэдээллийн технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл 3 удаа, Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөл 10 удаа хуралдсан. | **Эхний хагас жилд:**<br>Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлыг зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийг албажуулж, тайлагнасан байна. | Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 3 удаагийн хурлыг зохион байгуулж 1 гэрээт ажлын үр дүн, 2 БНбД, 2 ажлын даалгавар хэлэлцүүлэв. Хурлаар хэлэлцсэн асуудлуудын хурлын тэмдэглэлийг нэгтгэж цэгцлэн баталгаажуулав.<br>Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлууд батлагдан холбогдох шийдвэрүүд гарсан.<br>Орон зайн мэдээллийн технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж 6 ажлын даалгаврыг хэлэлцүүлж батлуулсан. | |

## ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | Үйл ажиллагаа | Үүрэг даалгаврын тоо | Жил бүр хийгддэг. | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна. | Байгууллагын 20 удаагийн шуурхай хуралдаанаас өгсөн 54 үүрэг даалгаврыг цаг тухай бүр хэрэгжүүлж, тайлагнав. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Цахим системүүдийн хандах эрхийн судалгааг гаргаж, удирдлагад танилцуулсан.<br>www.gazar.gov.mn Байгууллагын вэб хуудасны Орон зайн өгөгдөл хэсэгт 6 төрөлд багтах нийт 19 мэдээллийг шинэчлэн байршуулсан. | |
| 4.1.2 | Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Тушаалд заасан хугацаа | Жил бүр хийгддэг. | Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна. | - 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/36 дугаар тушаалаар байгуулагдсан "ISO 19119 Газарзүйн мэдээлэл-Үйлчилгээ, ISO 19115-Газарзүйн мэдээлэл-Метадата стандартыг орчуулах, шинэчлэн батлуулах, MNS 6925 1:18 Газарзүйн мэдээлэл-Өгөгдөл техникийн үзүүлэлт стандартын дагуу бусад байгууллагын санг хөрвүүлэх ажил"-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороо;<br>- 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/70 дугаар тушаалаар байгуулагдсан "Газрын кадастрын систем, Газрын нэгдмэл сангийн систем, Хот байгуулалтын кадастрын систем, И-газар системийн хөгжүүлэлт хийх ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороо;<br>- 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн Газрын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даргын А/56, А/57 дугаартай ажлын хэсгийн гишүүн;<br>- 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар "Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн өгөгдлийн санг шинэчлэн зохион байгуулах, хэрэглэгчийн програм хангамжийн хөгжүүлэлт ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороо;<br>- 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/98 дугаар тушаалаар байгуулагдсан "Газрын хяналт, шалгалтын цахим системийн хөгжүүлэлтийн ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороо;<br>- 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Газрын даргын А/152 дугаар тушаалаар байгуулагдсан. "Орон зайн өгөгдлийн мэдээллийн санд чанарын шалгалт хийж, баяжуулалт, атрибут мэдээг бүрдүүлэх ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороо. | |
| 4.1.3 | Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | Жил бүр хийгддэг. | Холбогдогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна. | Засгийн газрын 2024 оны 173 дугаар тогтоолыг хамаарах нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллах тухай 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 1/4321 дугаартай албан бичгийг 21 аймгийн ГХБХБГ, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийслэлийн ГЗБА-нд хүргүүлсэн. Мөн ухаалаг төхөөрөмж (киоск) хөгжүүлэгч “Эрхэт инноваци” ХХК, “Смарт дата” ХХК-тай хамтран шаардлагатай хөгжүүлэлтийг хийж, шинэчлэгдсэн хураамжийн хэмжээгээр төлбөр тооцох боломжийг бүрдүүлэн хэрэглээнд гаргасан.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны “2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврын 5.5 дугаарт авлигатай тэмцэх "5Ш" ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилт, үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлэх чиглэл өгсөн тул байгууллагын вэб хуудас болон зарын самбарт шинэчлэх шаардлагатай мэдээ, мэдээллийг байршуулж Шил ажиллагааны цахим системд холбож, 1 дүгээр улирлын тайланг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Төрийн цахим үйлчилгээ зохицуулалтын газарт илгээсэн.<br>“Алсын хараа-2050”-ын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр ТЗУГ-т хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.4 | Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | Үйл ажиллагаа | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо | Жил бүр хийгддэг. | Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Хүлээн авсан албан бичиг-88;<br>Шийдвэрлэсэн албан бичиг-75;<br>Төлөвлөж хүргүүлсэн албан бичиг-75;<br>Өргөдөл, гомдол-4. | |
| 4.1.5 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Үйл ажиллагаа | Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо | Жил бүр хийгддэг. | Нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | 2024 оны Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлын материал болох 144 хуудас баримтыг албан хэрэг хөтлөлтийн шаардлагын дагуу бүрдүүлж товьёг үйлдэн байгууллагын архив хүлээлгэн өгөв.<br>Байгууллагын дата төвийн цахилгааны нөөц эх үүсвэр" (дизель генератор)-ийн худалдан авалт, суурилуулалт хийх тендер шалгаруулалтын 366 хуудас, 2 боть баримт бичгийг Төрийн архивт баримт хүлээн авах журмын дагуу 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хүлээлгэн өгсөн.<br>Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх, шалгаж хүлээн авах журамын 3.4.10-3.4.13-т заасны дагуу "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг байгууллагуудын мэдээллийн сантай холбож, дундын мэдээллийн сан байгуулах" гэрээт ажлын "Ажил шалгаж хүлээн авсан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүгнэлт"-ийг 3% үйлдэж, эх материал, тайлан, CD-ны хамт салбарын архивын хэлтэст хүлээлгэн өгсөн.<br>2025 оны худалдан авах ажиллагааны дараах материалуудыг албан хэрэг хөтлөлтийн шаардлагын дагуу бүрдүүлж товъёг үйлдэн байгууллагын архив хүлээлгэн өгөв. Үүнд:<br>- "Газрын зургийн систем хийх" ТЭЗҮ боловсруулах тендер шалгаруулалтын баримт бичиг, холбогдох материал-93 хуудас;<br>- Газар зүйн нэрийг полигонжуулах, арга аргачлал боловсруулах ажил (Сүхбаатар аймаг) тендер шалгаруулалтын баримт бичиг, холбогдох материал-171 хуудас;<br>- Хаягийн тэмдэг, тэмдэглэгээний стандартыг шинэчлэн батлуулах, хаяг олгох үйл ажиллагааны журам батлуулах ажил тендер шалгаруулалтын баримт бичиг, холбогдох материал-97 хуудас; | |
| **Стратегийн төлөвлөгөөний зорилго 4.2. Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох** | | | | | | | |
| **4.2.2** | **Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох** | **Үйл ажиллагаа** | **Жил бүр 5-аас доошгүй эрх зүйн акт** | **Жил бүр 10 орчим эрх зүйн акт боловсруулж байна.** | **Нийт эрх зүйн актын 80 орчим хувийг шинэчилсэн байна.** | | |
| 4.2.2.2 | "Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг | Үйл ажиллагаа | Журмын төсөл, Засгийн газрын | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай | **Жилийн эцэст:**<br>Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг | Хугацаа болоогүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохицуулах журам"-ын төслийг боловсруулах | | тогтоолын төсөл | хуулийн төсөлд тусгагдсан. | зохицуулах журмын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авсан байна.<br>Журмын төслийг ДДЗХ-аар хэлэлцүүлсэн байна. | | |
| 4.2.2.3 | "Геопорталыг ажиллуулах журам"-ын төслийг боловсруулж, холбогдох байгууллагад батлуулахаар хүргүүлэх | Үйл ажиллагаа | Журам-1, Засгийн газрын тогтоолын төсөл-1 | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлд тусгагдсан. | **Эхний хагас жилд:**<br>"Геопорталыг ажиллуулах журам"-ын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авсан байна. | Журмын төслийг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна. | |
| 4.2.2.4 | Хаягийн тэмдэг, тэмдэглэгээний стандартыг шинэчлэн боловсруулах, хаяг олгох үйл ажиллагааны журам | Урсгал зардал | Шинээр боловсруула-хаар төлөвлөсөн стандарт-1; журам-1 | "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага" MNS5283:2022<br><br>Засгийн газрын 2019оны 325 дугаар тогтоолоор баталсан "Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам"-д | **Эхний хагас жилд:**<br>Эрх зүйн баримт бичгийг боловсруулах ажлыг зохион байгуулж, ажлыг эхлүүлнэ.<br>Хаягийн тэмдэг, тэмдэглэгээний стандарт;<br>Хаяг олгох үйл ажиллагааны журам; | Тус ажлыг гүйцэтгэх тендер шалгаруулалтын Ажлын даалгаврыг боловсруулан Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр АД/2025-17 дугаартай батлуулсан. Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/52 дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулсан. Тендер шалгаруулалтыг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр худалдан авах ажиллагааны https://tender.gov.mn цахим системд нийтэлсэн.<br>2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр тендерийг нээж, 3 оролцогчийн ирүүлсэн тендерийг хянан үзэж үнэлэн, хамгийн сайн тендер ирүүлсэн Г.Нарантуяа ахлагчтай багийг шалгаруулахыг 2025.03.21-ний өдөр захиалагчид санал болгосон.<br>Захиалагч санал болгосон оролцогчийг Ажлын даалгавар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулахад оролцсон гэж үзэн шалгаруулахаас татгалзсан.<br>Тендерт оролцогчдод шаардлага хангасан тендер ирээгүй болох мэдэгдлийг 2025.04.07-ны өдрийн 1/1157, 1/1158, 1/1159 дугаартай албан бичгээр хүргүүлэв. | |

## ТАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Хүрэх түвшин | Хэрэгжүүлэх ажил | Эхлэх, дуусах огноо |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | |
| 6.1 | Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Шинээр гарсан хууль, дүрэм, журам, тогтоол, шийдвэртэй тухай бүр танилцаж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүсэн байна. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хаягжуулалтын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Авто замын тухай хууль, Монгол хэлний тухай хуулийг тус тус судалж эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж байна. | 01-12 |
| 6.2 | Удирдлагын академийн Төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах | Мэдлэг, чадвараа дээшлүүлсэн байна. | Удирдлагын академийн Төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдан төгсөж, 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Е1688 дугаартай сертификат авсан. | 01-06 |
| 6.3 | ХААИС-д суралцах | Мэдлэг, чадвараа дээшлүүлсэн байна. | ХААИС-ийг Газар зохион байгуулагч мэргэжлээр суралцан төгсөж, 2025 оны 04 дүгээр сарын 22-ны | 09-06 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | өдрийн А/120 тушаалаар 6202503962 дугаартай бакалавр боловсролын зэргийн диплом авсан. | |
| 6.4 | Байгууллагаас болон төслөөс, олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдах | Мэдлэг, чадвараа дээшлүүлсэн байна. | 1.Тагнуулын ерөнхий газраас зохион байгуулсан "Төрийн болон албаны нууцын тухай хууль, журам түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд" сургалтад 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр хамрагдсан.<br>2.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2022 оны А/194 дүгээр тушаалын хавсралт "Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх, шалгаж хүлээн авах журмын 5.5-д заасны дагуу гүйцэтгэгч тал Мэдээлэл, технологийн хэлтсийн холбогдох албан хаагчид болон "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем"-ийн дэд системүүдийн админуудыг уг систем дээр ажиллаж мэргэшүүлэх, чадавхижуулах сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хамрагдсан. | Тухай бүр |
| 6.6 | Дотоодын болон олон улсын хурал, зөвлөгөөнд оролцож мэдлэг, мэдээлэл авах | Мэдлэг, мэдээлэл авсан байна. | 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулагдсан "Удирдах ажилтны зөвлөгөөн"-д оролцсон. Удирдах ажилтны зөвлөгөөнөөс орон зайн чиглэлээр гарсан саналыг нэгтгэн холбогдох зөвлөмжийг ТЗУГ-т хүргүүлсэн. | Тухай бүр |

--o0o--